



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Насан туршийн боловсролын төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/06/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цог-Эрдэнэ Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdene.g@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1. Аудитын дүгнэлт</b>	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба алдаа зөрчил илрээгүй болно. ....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17

#### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хувь



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН НАСАН ТУРШИЙН  
БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН ДАРГА  
Х.ОТГОНЦЭЦЭГ ТАНАА

2021.02.14 № 16  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Насан туршийн боловсролын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Насан туршийн боловсролын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхгүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,661,430.00	14,661,430.00
35	БАРАА МАТЕРИАЛ	14,661,430.00	14,661,430.00
35400	Хангамжийн материал	14,661,430.00	14,661,430.00
35410	Бичиг хэргийн материал	5,217,680.00	5,217,680.00
35420	Аж ахуйн материал	9,443,750.00	9,443,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	20,930,408.47	32,065,370.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,930,408.47	32,065,370.95
39200	Биет хөрөнгө	20,681,075.28	31,904,037.78
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	18,766,800.00	21,132,670.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,888,716.43)	(3,311,160.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,455,000.00	27,253,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,878,708.29)	(13,397,172.13)
39217	Ном	226,700.00	226,700.00
39300	Биет бус хөрөнгө	249,333.19	161,333.17
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-630,666.81	-718,666.83
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	35,591,838.47	46,726,800.95
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	35,591,838.47	46,726,800.95
51	Засгийн газрын хувь оролцоо	35,591,838.47	46,726,800.95
51200	Хуримтлагдсан үр дүн	35,591,838.47	46,726,800.95
51210	Өмнөх үеийн үр дүн	40,477,630.71	35,591,838.47
51220	Тайлант үеийн үр дүн	(4,885,792.24)	11,134,962.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	35,591,838.47	46,726,800.95

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	200,273,600.00	186,968,670.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0	18,993,870.00
120	Нийтлэг татварын бус орлого	0	18,993,870.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	18,993,870.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	200,273,600.00	167,974,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	158,539,620.00	145,345,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	158,539,620.00	145,345,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,323,500.00	33,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,323,500.00	33,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37,410,480.00	22,596,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,410,480.00	22,596,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	205,159,392.24	175,358,707.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	205,159,392.24	175,358,707.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	195,762,076.60	174,408,703.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	100,318,617.19	105,780,703.50
210101	Үндсэн цалин	76,341,327.49	74,817,802.20
210102	Нэмэгдэл	15,688,804.70	15,899,259.43
210104	Урамшуулал	8,288,485.00	15,063,641.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,056,738.67	13,838,100.00
210201	Тэтгэврийн даатгал	10,887,478.67	10,516,076.43
210202	Тэтгэмжийн даатгал	668,890.00	907,553.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	560,970.00	533,103.32
210204	Ажилгүйдлийн даатгал	176,300.00	165,466.70
210205	Эрүүл мэндийн даатгал	1,763,100.00	1,715,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,189,032.00	22,595,992.29
210301	Гэрэл, цахилгаан	5,705,980.00	535,847.29
210302	Түлш, халаалт	16,342,272.00	21,789,696.00
210303	Цэвэр, бохир ус	140,780.00	270,449.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,787,620.00	4,327,250.00
210401	Бичиг хэрэг	873,900.00	292,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,500,000.00	2,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	670,400.00	1,110,400.00
210404	Ном, хэвлэл	12,500.00	66,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	75,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	730,820.00	281,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,359,100.00	0.00
210604	Урсгал засвар	15,359,100.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	848,000.00	663,400.00
210702	Дотоод албан томилолт	848,000.00	663,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,932,300.00	1,791,500.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,732,300.00	1,763,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	28,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,270,668.74	25,411,757.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,814,480.00	18,027,850.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,456,188.74	7,383,907.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,397,315.64	950,004.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	71,500.00	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	71,500.00	900,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,912,968.00	7.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,912,968.00	7.71
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,412,847.64	49,996.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,412,847.64	49,996.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-4,885,792.24	11,609,962.48
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	475,000.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	475,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-4,885,792.24	11,134,962.48

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	40,477,630.71	40,477,630.71
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	40,477,630.71	40,477,630.71
4	Тайлант үеийн үр дүн	0	0	(4,885,792.24)	(4,885,792.24)
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	35,591,838.47	35,591,838.47
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	35,591,838.47	35,591,838.47
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	35,591,838.47	35,591,838.47
9	Тайлант үеийн үр дүн	0	0	11,134,962.48	11,134,962.48
10	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0	0	46,726,800.95	46,726,800.95

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	200,273,600.00	167,974,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	200,273,600.00	167,974,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	158,539,620.00	145,345,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	158,539,620.00	145,345,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,323,500.00	33,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,323,500.00	33,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37,410,480.00	22,596,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,410,480.00	22,596,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	200,046,900.00	167,974,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	200,046,900.00	167,974,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	190,649,584.36	167,024,795.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	100,723,270.69	105,780,703.50
210101	Үндсэн цалин	73,325,723.99	75,961,905.96
210102	Нэмэгдэл	19,109,061.70	15,899,259.43
210104	Урамшуулал	8,288,485.00	13,919,538.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,622,081.67	13,838,100.00
210201	Тэтгэврийн даатгал	10,095,981.67	10,406,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	881,500.00	857,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	705,200.00	686,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	176,300.00	171,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,763,100.00	1,715,900.00

Архангай аймгийн Насан туршийн боловсролын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,189,032.00	22,595,992.29
210301	Гэрэл, цахилгаан	246,136.00	523,427.29
210302	Түлш, халаалт	21,789,696.00	21,789,696.00
210303	Цэвэр, бохир ус	153,200.00	282,869.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,396,200.00	4,583,100.00
210401	Бичиг хэрэг	713,300.00	272,400.00
210402	Тээвэр, шатахуун	3,500,000.00	2,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	670,400.00	1,110,400.00
210404	Ном, хэвлэл	12,500.00	362,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	75,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	262,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,562,700.00	0.00
210604	Урсгал засвар	16,562,700.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	848,000.00	663,400.00
210702	Дотоод албан томилолт	848,000.00	663,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,932,300.00	1,791,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,732,300.00	1,763,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	28,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,376,000.00	17,772,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,376,000.00	17,772,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,397,315.64	950,004.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	71,500.00	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	71,500.00	900,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,912,968.00	7.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,912,968.00	7.71
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,412,847.64	49,996.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,412,847.64	49,996.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	226,700.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	226,700.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	226,700.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	226,700.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	226,700.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-226,700.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	167,941,800.00	167,891,795.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	167,941,800.00	167,891,795.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	167,041,800.00	166,991,795.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	105,830,200.00	105,780,703.50
210101	Үндсэн цалин	83,271,500.00	75,961,905.96
210102	Нэмэгдэл	13,897,900.00	15,899,259.43
210104	Урамшуулал	8,660,800.00	13,919,538.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,838,600.00	13,838,100.00
210201	Тэтгэврийн даатгал	10,663,500.00	10,406,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	793,800.00	857,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	635,000.00	686,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	158,700.00	171,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,587,600.00	1,715,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,596,000.00	22,595,992.29
210301	Гэрэл, цахилгаан	988,100.00	523,427.29
210302	Түлш, халаалт	21,129,300.00	21,789,696.00
210303	Цэвэр, бохир ус	478,600.00	282,869.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,550,100.00	4,550,100.00
210401	Бичиг хэрэг	272,400.00	272,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	2,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,110,400.00	1,110,400.00
210404	Ном, хэвлэл	362,400.00	362,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	42,100.00	42,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	262,800.00	262,800.00
2107	Томилолт, зочны зардал	663,400.00	663,400.00
210702	Дотоод албан томилолт	663,400.00	663,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,791,500.00	1,791,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,763,500.00	1,763,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	28,000.00	28,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,772,000.00	17,772,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,772,000.00	17,772,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	900,000.00	900,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	900,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	167,941,800.00	167,891,795.79
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	145,345,800.00	145,295,803.50
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	145,345,800.00	145,295,803.50
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,596,000.00	22,595,992.29
320001	Орон нутгийн төсвөөс	22,596,000.00	22,595,992.29
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	8.5	8.5

620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	7.5	7.5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	8.5	8.5
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2.5	8.5

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон / төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,000.00
2132	Хангамж бараа матерриалын зардал	33,000.00
213209	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,000.00
131104	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Насан туршийн боловсролын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Насан туршийн боловсролын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Насан туршийн боловсролын төв нь Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Насан туршийн боловсролын сургалт, судалгаа, арга зүйн байгууллага орон нутгийн насан туршийн болон албан бус боловсролын байгууллагыг нэгдсэн удирдлага, бодлого зохицуулалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, энэ чиглэлээр боловсрол олгож байгаа багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах үйл ажиллагааг эрхэлнэ”, 17.3-т “Насан туршийн болон албан бус боловсролын сургалт, судалгаа, арга зүйн байгууллагын дүрэм, зохион байгуулалтын бүтцийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг, БШУГ-ын харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Нийгмийн бүхий л орчин, цаг хугацаа, хэрэгцээ боломжид нийцүүлэн боловсрол эзэмшүүлэх, хүн бүрд адил тэгш олгох, төр, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах, орон нутгийн иргэдийн насан туршийн тасралтгүй боловсролын тогтолцоог бэхжүүлэх”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн БШУГ-ын төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Насан туршийн боловсролын төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

### 3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 167.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 1.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 11.1 сая төгрөгөөр буюу 31.3 хувиар өссөн ба материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая.төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	14.6	14.6	-	-
Үндсэн хөрөнгө	20.9	32.0	11.1	53.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>35.5</b>	<b>46.6</b>	<b>11.1</b>	<b>31.3</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	35.5	35.5	-	-

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	35.5	35.5	-	-
--	------	------	---	---

### 3.5.1. Бараа материалын үлдэгдэл 14.6 сая төгрөг байна.

Бараа материалын данс нь 14.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 16.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 16.3 сая төгрөгийн зарцуулалт гарч, 14.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### 3.5.2. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 53.1 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 20.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 18.4 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 7.3 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 32.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**3.5.3.** Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 11.1 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой.

## Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/ төгрөгөөр/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/орон нутгийн төсөв/	37,481,200.00	22,596,000.00	-14,885,200
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт - /улсын төсөв/	158,468,900.00	145,345,800.00	-13,123,100
Нэмэлт санхүүжилтийн орлого	4,323,500.00	33,000.00	-4,290,500
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	18,993,870.00	18,993,870
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>200,273,600.00</b>	<b>186,968,670.00</b>	<b>-13,304,930</b>
Цалин, шимтгэлийн зардал	114,375,355.86	119,618,803.50	5,243,448
Бусад бараа үйлчилгээний зардал	81,386,720.74	54,789,899.81	-26,596,821
Урсгал шилжүүлэг	9,397,315.64	950,004.21	-8,447,311
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>205,159,392.24</b>	<b>175,358,707.52</b>	<b>-29,800,685</b>
<b>Үйл ажиллагааны бус зардал /ҮХХ-ны гарз/</b>	<b>0.00</b>	<b>475,000.00</b>	<b>475,000</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-4,885,792.24</b>	<b>11,134,962.48</b>	<b>16,020,755</b>

Аймгийн НТБТ-ийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 13,123.1 мянган төгрөг буюу 8.2 хувиар буурсан нь төсвийн хэмнэлттэй холбоотойгоор хангамж бараа материалын зардал болон бараа үйлчилгээний бусад зардлууд буурсан байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

## 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 206.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 75.6 сая төгрөгөөр бууруулж 130.5 сая төгрөгөөр хянасан байна. Харин төсвийн тодотголоор 28.6 хувиар буюу 37.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсвийг 167.9 сая төгрөг болгон баталжээ. Төсөв нэмэгдсэн шалтгаан нь дээд шатны төсөв захирагч 2021 оны төсвийг 2 орон тоогоор дутуу баталсныг төсвийн тодотголоор нэмж цалин, НДШ-ийн зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 167.9 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 167.8 сая төгрөгийг зарцуулж, 0.01 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, тайлант онд батлагдсан төсвийг 0.03 хувиар хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн БСУГ-аас 0.03 сая төгрөгийн санхүүжилт ирснийг ажлын байрны халдваргүйжилт ариутгал хийхэд зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлангийн жилд тус байгууллага нь гэр бүлийн боловсрол, харилцаа ёс зүйн боловсрол, амьдрах ухааны боловсрол, соёл гоо зүйн боловсрол, иргэний эрх зүйн боловсрол гэсэн 5 чиглэлээр 86 удаагийн цахим хичээл /контент/-ийг бэлтгэн цахим хаягаар түгээж 16.7 мянган иргэнд, 210 удаагийн лайв сургалтыг зохион байгуулж 7.7 мянган хүнд хүргэсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 98 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 167.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэл 99.9 хувь байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд шинээр орон тоо нэмэгдүүлээгүй, автомашин, албан конторын тавилга, албаны болон дүрэмт хувцас, танхимын сургалт зэрэгт төсөв зарцуулаагүй байна.
- Албан хаагчдын үр дүнгийн урамшуулал, албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба алдаа зөрчил илрээгүй болно.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Архангай аймгийн Насан туршийн боловсролын төв нь 2021 онд нийт 136.5 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн байршуулсан байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 10 % буюу 4.8 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилты холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн тул аудитаас зөвлөмж өгөөгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

-----oO-----

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
Дүн											
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	НТБТ	1	4.8					1	4.8		
Дүн		1	4.8					1	4.8		
Нийт дүн		1	4.8					1	4.8		